

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2022/124/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Өмнөговь аймаг
Даланзадгад сум
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: tserenbayars@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Шижирболд
Утас: 70005329 Цахим хаяг: shijirboldg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
4. Аудитын илрүүлэлт	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

46083, Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 3 дугаар баг,
Нутгийн удирдлагын ордон 304 тоот
Утас: (976) 7053 3539, Вэб сайт: www.audit.mn
И-мэйл: umnugovi@audit.gov.mn

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ХАНБОГД СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН
ПРОКУРОРЫН ГАЗРЫН ЕРӨНХИЙ
ПРОКУРОР, ХУУЛЬ ЦААЗЫН ИТГЭМЖИТ
ЗӨВЛӨХ Б.ЭНХМЭНД ТАНАА

2022.02.18 № 55
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЦЭРЭНБАЯР

Д:2021 Он/Бичиг Хэрэг/Явсан Бичиг/2022-02-18 №55

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөг/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,595,603.00</u>	<u>3,076,603.00</u>
33	АВЛАГА	97,603.00	97,603.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	97,603.00	97,603.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,498,000.00	2,979,000.00
354	Хангамжийн материал	2,498,000.00	2,979,000.00
35470	Бусад хангамжийн материал	00.00	2,979,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>524,770,880.60</u>	<u>530,708,336.86</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	524,770,880.60	530,708,336.86
392	Биет хөрөнгө	449,770,880.60	455,708,336.86
39201	Барилга, байгууламж, орон сууц	405,040,940.64	405,040,940.64
39202	Хуримтлагдсан элэгдэл	-13,501,364.64	-20,252,046.96
39203	Авто-тээврийн хэрэгсэл	30,371,785.46	20,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-19,371,785.46	-12,999,999.96
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	44,482,983.29	65,287,671.29
39206	Хуримтлагдсан элэгдэл	-12,640,801.90	-22,065,364.96
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,404,980.43	37,417,980.43
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23,301,287.08	-24,710,365.24
39214	Бусад үндсэн хөрөнгө	8,877,246.34	8,877,246.34
39215	Хуримтлагдсан элэгдэл	-591,816.48	-887,724.72
393	Биет бус хөрөнгө	75,000,000.00	75,000,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	75,000,000.00	75,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>527,366,483.60</u>	<u>533,784,939.86</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>527,366,483.60</u>	<u>533,784,939.86</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	527,366,483.60	533,784,939.86
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	75,000,000.00	75,000,000.00
51101	Өмч: - төрийн	75,000,000.00	75,000,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	445,586,643.70	452,005,099.96
51210	Өмнөх үеийн үр дүн	445,586,643.70	445,586,643.70
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	6,418,456.26
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,779,839.90	6,779,839.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>527,366,483.60</u>	<u>533,784,939.86</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөг/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<u>302,383,764.39</u>	<u>395,311,488.00</u>

11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
110	Орлогын албан татвар	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	22,021,464.39	19,488,188.00
120	Нийтлэг татварын бус орлого	22,021,464.39	19,488,188.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	21,471,953.39	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	21,471,953.39	00.00
120009	Бусад орлого	549,511.00	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн орлого-үндсэн хөрөнгө		16,509,188.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн орлого-бараа материал		2,979,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	280,362,300.00	375,823,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	280,362,300.00	375,823,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	280,362,300.00	375,823,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	00.00
1330	Төсвийн захирагчдаас	00.00	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	00.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	290,393,630.54	388,893,031.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	290,393,630.54	388,893,031.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	284,439,255.59	347,890,130.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	196,707,448.00	240,665,289.94
210101	Үндсэн цалин	165,647,391.00	171,812,518.00
210102	Нэмэгдэл	31,060,057.00	54,977,772.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	13,874,999.72
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,250,843.48	29,917,734.58
210201	Тэтгэврийн даатгал	16,671,967.29	20,850,166.81
210202	Тэтгэмжийн даатгал	1,967,076.07	2,335,905.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,573,659.46	1,868,724.39
210204	Ажилгүйдлийн даатгал	367,103.70	442,085.33
210205	Эрүүл мэндийн даатгал	3,671,036.97	4,420,852.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,204,000.00	15,875,200.00
210301	Гэрэл, цахилгаан	2,880,000.00	2,803,200.00
210302	Түлш, халаалт	13,324,000.00	11,872,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,292,187.00	15,329,810.00
210401	Бичиг хэрэг	5,858,200.00	6,381,810.00
210402	Тээвэр, шатахуун	4,735,000.00	3,825,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,272,437.00	1,675,950.00
210404	Ном, хэвлэл	24,900.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,750,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	651,650.00	3,447,050.00
2105	Норматив зардал	65,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	65,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,261,100.00	6,691,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,206,400.00
210604	Урсгал засвар	5,261,100.00	5,485,400.00

2107	Томилолт, зочны зардал	24,000.00	437,000.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	24,000.00	437,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,379,100.00	10,661,064.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,860,000.00	10,090,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	519,100.00	519,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	29,064.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	22,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,255,577.11	28,312,231.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	432,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,650,000.00	6,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,605,577.11	21,880,231.74
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,954,374.95	41,002,901.48
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,380,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,380,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,574,374.95	41,002,901.48
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,574,374.95	41,002,901.48
213304	Хөрөнгийн	00.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>11,990,133.85</u>	<u>6,418,456.26</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	00.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>11,990,133.85</u>	<u>6,418,456.26</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>280,911,811.00</u>	<u>375,823,300.00</u>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
110	Орлогын албан татвар	00.00	00.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	549,511.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	549,511.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	00.00
120009	Бусад орлого	549,511.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	280,362,300.00	375,823,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	280,362,300.00	375,823,300.00

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	280,362,300.00	375,823,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	00.00
1330	Төсвийн захирагчдаас	00.00	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	00.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	280,911,811.00	364,514,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	280,911,811.00	364,514,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	275,417,436.05	323,511,898.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	193,244,749.05	240,665,289.94
210101	Үндсэн цалин	138,394,199.05	171,812,518.00
210102	Нэмэгдэл	49,620,000.00	54,977,772.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,230,550.00	13,874,999.72
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,456,800.00	29,917,734.58
210201	Тэтгэврийн даатгал	19,684,400.00	20,850,166.81
210202	Тэтгэмжийн даатгал	1,943,100.00	2,335,905.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,554,500.00	1,868,724.39
210204	Ажилгүйдлийн даатгал	388,600.00	442,085.33
210205	Эрүүл мэндийн даатгал	3,886,200.00	4,420,852.44
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,204,000.00	15,875,200.00
210301	Гэрэл, цахилгаан	2,880,000.00	2,803,200.00
210302	Түлш, халаалт	13,324,000.00	11,872,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,400,187.00	12,831,810.00
210401	Бичиг хэрэг	6,058,200.00	4,331,810.00
210402	Тээвэр, шатахуун	4,735,000.00	3,825,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,732,437.00	1,675,950.00
210404	Ном, хэвлэл	24,900.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,750,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,099,650.00	2,999,050.00
2105	Нормативт зардал	65,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	65,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,143,600.00	6,691,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,000,000.00	1,206,400.00
210604	Урсгал засвар	5,143,600.00	5,485,400.00
2107	Томилолт, зочны зардал	24,000.00	437,000.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	24,000.00	437,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,379,100.00	10,661,064.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,860,000.00	10,090,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00

210803	Даатгалын үйлчилгээ	519,100.00	519,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	29,064.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	22,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,500,000.00	6,432,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	432,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,500,000.00	6,000,000.00
211	ХҮҮ	00.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,494,374.95	41,002,901.48
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	920,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,574,374.95	41,002,901.48
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,574,374.95	41,002,901.48
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	11,308,500.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	11,308,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	11,308,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	11,308,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	11,308,500.00
2260	Гадаад эх үүсвэрээр	00.00	00.00
226001	Гадаад эх үүсвэрээр	00.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-11,308,500.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
14	Бусад эх үүсвэр	00.00	00.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	00.00	00.00
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	00.00	00.00
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	75,000,000.00	6,779,839.90	433,596,509.85	00.00	515,376,349.75
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	75,000,000.00	6,779,839.90	433,596,509.85	00.00	515,376,349.75
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	11,990,133.85	00.00	11,990,133.85
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	75,000,000.00	6,779,839.90	445,586,643.70	00.00	527,366,483.60
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	75,000,000.00	6,779,839.90	445,586,643.70	00.00	527,366,483.60
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	75,000,000.00	6,779,839.90	445,586,643.70	00.00	527,366,483.60
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	6,418,456.26	00.00	6,418,456.26
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	75,000,000.00	6,779,839.90	452,005,099.96	00.00	533,784,939.86

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	375,823,300.00	334,820,398.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	375,823,300.00	334,820,398.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	375,323,300.00	334,820,398.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	258,131,500.00	240,665,289.94
210101	Үндсэн цалин	177,929,700.00	171,812,518.00
210102	Нэмэгдэл	64,805,800.00	54,977,772.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,396,000.00	13,874,999.72
210104	Урамшуулал	00.00	00.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,366,700.00	29,917,734.58
210201	Тэтгэврийн даатгал	22,612,700.00	20,850,166.81
210202	Тэтгэмжийн даатгал	2,438,500.00	2,335,905.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,950,800.00	1,868,724.39
210204	Ажилгүйдлийн даатгал	487,700.00	442,085.33
210205	Эрүүл мэндийн даатгал	4,877,000.00	4,420,852.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол	15,875,200.00	15,875,200.00

	зардал		
210301	Гэрэл, цахилгаан	2,803,200.00	2,803,200.00
210302	Түлш, халаалт	11,872,000.00	11,872,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	1,200,000.00
210304	Байрны түрээс	00.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,896,700.00	12,831,810.00
210401	Бичиг хэрэг	5,587,500.00	4,331,810.00
210402	Тээвэр, шатахуун	5,100,000.00	3,825,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,000,000.00	1,675,950.00
210404	Ном, хэвлэл	409,200.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	800,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000,000.00	2,999,050.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	00.00
2105	Нормативт зардал	00.00	00.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	00.00
210502	Хоол, хүнс	00.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,588,000.00	18,000,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,500,000.00	5,501,900.00
210602	Тавилга	5,000,000.00	5,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	00.00
210604	Урсгал засвар	11,088,000.00	7,498,400.00
2107	Томилолт, зочны зардал	4,000,000.00	437,000.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	4,000,000.00	437,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,465,200.00	10,661,064.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,195,000.00	10,090,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	519,100.00	519,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	109,100.00	29,064.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	00.00
210807	Газрын төлбөр	20,000.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	00.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	00.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.00	6,432,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,000,000.00	432,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,000,000.00	6,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500,000.00	00.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал	500,000.00	00.00

	урамшуулал		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	00.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	375,823,300.00	334,820,398.52
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	375,823,300.00	334,820,398.52
131001	Улсын төсвөөс санхүүжих	375,823,300.00	334,820,398.52
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	00.00
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	00.00	00.00
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	00.00	00.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	00.00	00.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	11.00	11.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	04.00	04.00
620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Шижирболд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Т.Хонгорзул, дарга, тэргүүлэх аудитор С.Цэрэнбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 2/100 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын прокурорын газрын үйл ажиллагааны зорилго нь "Зөрчлийн хэрэг, мөрдөн байцаах ажиллагаа, төр нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, ял эдлүүлэх ажиллагаанд прокурорууд хяналт тавин ажиллаж төр нийтийн төлөө" гэж тодорхойлжээ.

Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын прокурорын газрын хэрэгжүүлэх стратеги зорилтуудыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Байгууллагын үйл ажиллагааг их өгөгдөлд суурилсан бодлогын инновацаар удирдах.
- Хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсэн эрхийг нөхөн сэргээх.
- Прокурорын байгууллагын үйл ажиллагааг иргэдэд ил тод, нээлттэй, хялбар болгох.
- Прокурор, ажилтны мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, нийгмийн хөгжлийн шинэ хандлагад нийцсэн хувь хүнийг төлөвшүүлэх.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл 2,903.9 мянган төгрөг гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 290,393.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 2,903.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2,323.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын прокурорын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,418.4 мянган төгрөгөөр буюу 1.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүнгийн данс байна.

. Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт

Б	1	2	3=2-1
Авлага	97.6	97.6	0.00
Бараа материал	2,498.0	2,979.0	481.0
Биет хөрөнгө	449,770.9	455,708.3	5,937.4
Биет бус хөрөнгө	75,000.0	75,000.0	0.00
Нийт хөрөнгө	527,366.5	533,784.9	6,418.4
Хуримтлагдсан үр дүн	445,586.6	452,005.1	6,418.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	527,366.5	533,784.9	6,418.4

Бараа материалын дансны үлдэгдэл 481.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд хангамжийн материал 481.0 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ. Оны эцэст их хэмжээний худалдан авалт хийж бараа материалын нөөц үүссэн асуудал байхгүй байна.

Биет хөрөнгө дансны үлдэгдэл 5,937.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 4,295.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 7,013.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэнтэй холбоотойгоор нэмэгдсэн.

Биет бус хөрөнгийн дүн өнгөрсөн оноос 00.0 мянган төгрөгөөр өөрчлөлт ороогүй байна.

Хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэл 6,418.5 мянган төгрөг болж өссөн нь тайлант оны хандивын бараа материал, үндсэн хөрөнгийн өсөлт зэргээс шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 98,530.7 мянган төгрөгөөр буюу 33.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, бусад урсгал шилжүүлгийн зардлууд байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлсэн байна.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тусгай зориулалтын шилжүүлгээс 375,823.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн 375,823.3 мянган төгрөгийг урсгал зардал зарцуулахаар батлагдаж, нийт зардлын 375,823.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 375,823.3 мянга төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 334,820.4 мянган төгрөгийг зарцуулж 41,002.9 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 334,820.4 мянган төгрөг буюу 89.1 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 17,466.2 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 2,449.0 мянга, хангамж, бараа материалын зардал 7,064.9 мянга, эд хогшил худалдан авах 4,587.7 мянга, томилолт, зочны зардал 3,563.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 1,804.1 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 3,568.0, бусад урсгал шилжүүлэг 500,0 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант онд урсгал зардлаас 2,013.0 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна. Мөн тус байгууллагын үндсэн хөрөнгөнд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 45 ширхэг үндсэн хөрөнгө байна. Эдгээр хөрөнгийг актлах, устгах, зарим ашиглах боломжтой үндсэн хөрөнгөнд үнэ тогтоох шаардлагатай байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн бөгөөд нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгаж тусгасан болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 135 мэдээллийг хугацаанд нь 81, хугацаа хоцроож 54-ыг мэдээлсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар тус байгууллагын 2020 оны санхүүгийн тайланд аудит хийж, зөрчил арилгах 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн байна. Үүнээс 1 албан шаардлага, 1 зөвлөмжийг биелүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын цаг хугацаа богино байсан тул бараа материал, үндсэн хөрөнгөд тулган баталгаажуулалт хийгээгүй болно. Иймд дараагийн аудитаар тус байгууллагын бараа материал, үндсэн хөрөнгөд тооллого хийх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 59,727.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 57,714.8 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж хүргүүлэв.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын дүн 19,488.1 мянга, авто тээврийн хэрэгсэл 10,371.8 мянган төгрөгөөр зөрүүтэй,
- Тайлант онд бэлтгэсэн 4,295.5 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаж аваагүй,
- Өмнөх оны санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан 11,069.5 мянган төгрөгөөр зөрүүтэй,
- Харилцахаас 13 зарлагын 12,489.9 мянган төгрөгийн ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд хаасан байна.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1:

Үлдэх өртөггүй 45 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь УСНББОУС-17 "Үндсэн хөрөнгө", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж 1:

УСНББОУС-17 "Үндсэн хөрөнгө", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Илрүүлэлт 2:

Урсгал засварын зардлаас 2,013.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж 2:

Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	/мянган төгрөг/									
		Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын прокурорын газар	3	59,727.8	1	57,714.8	-	-	-	-	2	2,013.0